



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 04 дугаар сарын 27

Дугаар 15/63

Баян-Өндөр сум

Г


Т

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.1, 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтууд, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтооюор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4.2, 4.3 дахь заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны 56 дугаар тэмдэглэлийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Хамтдаа Эрдэнэтэд хөгжье” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг 11 дүгээр сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023  
оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Ээлжит XV  
хуралдааны 56 дугаар тогтоолын хавсралт

**“ХАМТДАА ЭРДЭНЭТЭД ХӨГЖЬЕ” ХӨТӨЛБӨР**  
**НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Монгол Улсын Засгийн газар “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичгийн боомт, эрчим хүч, аж үйлдвэржилт, хот хөдөөгийн тэнцвэрт хөгжил, ногоон хөгжил, төрийн бүтээмж зэрэг 6 багц асуудал туссан.

Хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах зорилтын хүрээнд орон нутгийг хөгжүүлэх, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих зорилгоор “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 419 дүгээр тогтоол, Засгийн газрын хуралдааны 56 дугаар тэмдэглэл, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 157-р захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2022-2024 онд хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөөгөөр салбарын яам, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн авч хэрэгжүүлэх ажлын чиглэлүүд батлагдсан.

Орхон аймаг орон нутгийн өнөөгийн нөхцөл байдал, нөөц боломж, аймгийн түүх, соёл, зан заншил, уламжлал, оюун санааны үнэт зүйлс, нийгэм, эдийн засаг, техник, технологи, үндэсний үйлдвэрлэлийн ололт амжилтыг шилжин ирэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд мэдээлэн сурталчлах, дэмжин ажиллах “Хамтдаа Эрдэнэтэд хөгжье” хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх) холбогдох бодлогын бичиг баримт, хөтөлбөр, үйл ажиллагаа, судалгаанд үндэслэн боловсруулагдсан.

**ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

2.1. “Хамтдаа Эрдэнэтэд хөгжье” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

2.1.1. Монгол Улсын хууль, хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох үндэсний хөтөлбөрүүд, аймаг орон нутгийн бодит нөөц бололцоо, бус нутгийн эдийн засгийг хөгжүүлэх, орон нутаг өөрийгөө бие даан санхүүжүүлэх эдийн засгийн бодлогод тулгуурлах;

2.1.2. Орхон аймагт шилжин ирж ажиллаж, амьдрах үйл ажиллагаа эрхлэн явуулахад үүсэх давуу тал болон үүсэж болзошгүй хүндрэл бэрхшээлийг зөв тооцон, мэдээллийг нээлттэй, тэгш, хүртээмжтэй түгээхийг чухалчилж, хувь хүн, ААН, байгууллагад хуулиар олгогдсон эрхийг дээдлэн хүндэтгэсэн, үүрэг хариуцлагыг ухамсарлуулан таниулж хандлагын өөрчлөлтөд уриалж, бизнесийн орчны тэгш боломж, шударга өрсөлдөөнийг эрхэмлэсэн, хөгжил дэвшил, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын таатай орчин, олон талт харилцааны онцлогуудыг уялдуулан тодорхойлох;

2.1.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд иргэд олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог дэмжих.

## ГУРАВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Хөтөлбөрийн зорилго нь аймагт шилжин ирж суурьшин ажиллаж амьдрах, иргэд, ААН, байгууллагыг угтан авахад шаардагдах бэлтгэлийг хангах, аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, аймаг орон нутгийн талаарх нэгдсэн ойлголт, мэдээллийн нэгдмэл удирдлага, зохицуулалтыг бий болгож цахимжуулах, төрийн үйлчилгээг ойлгомжтой, шуурхай болгох, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 419 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлэх замаар аймаг, сум орон нутгаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## ДӨРӨВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

4.1.“Хамтдаа Эрдэнэтэд хөгжье” хөтөлбөрийг дараах зорилтуудаар хэрэгжүүлнэ:

4.1.1.Орон нутгийн онцлог, түүх, соёл, өөрсдөд буй боломжийн талаар сурталчилж, орон нутгаа хөгжүүлэх;

4.1.2.Иргэдэд ажиллаж амьдрах, аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэх;

4.1.3.Эдийн засаг, нийгмийн харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.1.4.Мэргэжлийн ажиллах хүчний хомсдолыг багасгах, (үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц, барилга, аялал жуулчлал, мал аж ахуй, газар тариалан гэх мэт) аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн тодорхой салбарын хөгжлийг эрчимжүүлэх, албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр сургалт явуулах зэргээр зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг дэмжих;

## ТАВ.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

5.1.“Хамтдаа Эрдэнэтэд хөгжье” хөтөлбөрийг дараах чиглэлд тэргүүн ээлжид хэрэгжүүлнэ:

5.1.1.Амьдрах таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг өргөтгөх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, уялдаа холбоог хангах, хөрөнгө оруулалт татах;

5.1.2.Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхжүүлж аймагтаа ажлын байр нэмэгдүүлэх;

5.1.3.Боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

5.1.4.Үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, аймгийн брэнд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон сурталчлах; үйлдвэрлэл, аялал жуулчлал гэх мэт бодит хөрөнгө оруулалт оруулах салбараа эрэмбэлэн хөгжүүлэх, иргэдийн тогтмол орлого олох боломжийг эрэлхийлэх;

5.1.5.Төр хувийн хэвслийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэдээллээр хангах, тэднийг аймаг орон нутагт шилжин ирж суурьшин амьдрах сэдлийг төрүүлэх, хандлагыг өөрчлөх, амьдрах таатай орчин бүрдүүлэх, мэдээллээр хангах, эдгээрт чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийг зохион байгуулж тогтмолжуулах;

## ЗУРГАА.ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх) ажиллана. Ажлын хэсгийн ахлагч нь Монгол Улсын ерөнхий сайдын 157 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүн, аймгийн засаг даргын орлогч байна.

6.2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга баталсан. Ажлын хэсэг нь 11 гишүүнтэй (хамтын ажиллагаа, иргэний бүртгэл, боловсрол, эруул мэнд, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, газрын харилцаа, хэвлэл мэдээллийн болон санхүү, төсөв, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн) ажилтны төлөөллөөс бүрдсэн.

6.3.Ажлын хэсэг аймгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулна.

6.4.Аймгаас мэдээллээ нээлттэй түгээх зорилгоор Улаанбаатар хот болон бус нутгийн түвшинд зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаа, форум, хурал зөвлөгөөн, спорт, соёл урлагийн арга хэмжээнд оролцож аймгаа сурталчлах асуудлыг Ажлын хэсгийн ахлагч шийдвэрлэх ба шаардлагатай тохиолдолд аймгийн Засаг даргатай зөвшилцэн Засаг даргын зөвлөлийн хурал болон ИТХ-ын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

6.5.Дэд ажлын хэсэг олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлах, үйл ажиллагааг Засгийн газрын дэргэдэх Ажлын хэсэгтэй хамтран нэгдсэн журмаар зохион байгуулах бөгөөд аймгийн хэмжээнд шинээр буй болсон ажлын байр, тухайн салбарт дутагдаж буй шаардлагатай боловсон хүчний судалгаа, шилжилт хөдөлгөөний бүртгэл зэрэг аймгийн нээлттэй мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлсэн байна. Улмаар төв мэдээллийн сантай мэдээлэл солилцох ажлыг орон нутаг дахь бүртгэл хариуцсан ажилтан шуурхай зохион байгуулна.

6.6.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад ажлын хэсгээс тогтмол хяналт тавьж, хагас болон бүтэн жилээр хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэж, холбогдох байгууллагуудад тайлагнана.

## ДОЛОО.ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Хөтөлбөрийн эхний шатыг 2023-2024 оны 1 дүгээр улирал дуустал нийт 15 сарын хугацаанд хэрэгжүүлнэ.

## НАЙМ.ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЭХ YYCBЭР

8.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ:

8.1.1.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

8.1.2.Хөгжлийн хөтөлбөрүүд, олон улсын байгууллагын тусlamжийн хөрөнгө;

8.1.3 Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;

8.1.4.Бусад.

8.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу тухайн жилийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн аймгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

## ЕС.ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

9.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

9.1.1.Аймагт шилжин ирсэн иргэдийн бодит тоон өсөлтийн хувь;

9.1.2.Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, бүтээн байгуулалт, аялал жуулчлал гэх мэт бүх төрлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн хувь;

9.1.3.Аймаг орон нутагт шинээр бий болсон ажлын байрны тоо;

9.1.4.Иргэд, ААН байгууллагууд, олон нийт рүү чиглэж тэдгээрийг татах чиглэлээр зохион байгуулсан ажлууд, түүний үр дүн;

9.1.5.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын

үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын "Хүн амын нэмэгдэлтийн хувь, төсвийн байгууллага, хуулийн этгээд тэдгээрийн салбар нэгжийн болон албан хаагчийн шилжилтийн хувь" шалгуур үзүүлэлтээр хэрхэн дүгнэгдсэн байдал.

9.2.Ажлын хэсэг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт бүрээр дүгнэж, тайлагнана.

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГТ  
ТУССАН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Шалгуур үзүүлэлт	Хэм жих	Суурь түвшин 2021	Хүрэх түвшин			Тайлбар	Мэдээ- лэл цуглуу- лах	Хариу- цах байгуул- лага	Мэдээ- лэл цуглуу- лах	Хүр- сэн түв шин
			2022	2023	2024					
<b>Дөрөв.Хүн амын нэмэгдэлт</b>										
Хүн амын нэмэгдэлтийн хувь	Хувь	2024	1938	80%	100%	2021 оны жилийн эцэст 106145 хүн амтай. 2022 онд 1938 шилжин ирсэн 1,8%-иар нэмэгдсэн. 2024 онд 127374 болгоно.	Жилд	ЗДТГ, УБХ, ААНБ	Статис- тик	1,8%
Хуулийн этгээд, тэдгээрийн салбар, нэгжийн шилжилтийн хувь	Хувь	5434	5451	1.5%	2,5%	Шилжин ирсэн ААНБ-ын тоо 2021 онд 10, 2022 онд 17-оор нэмэгдсэн. /өссөн үзүүлэлтээр тоолдог.	Жилд	ЗДТГ, УБХ, ААНБ	Статис- тик	0,3%
ААНБ-ын албан хаагчийн шилжилтийн хувь	Тоо	-	-	500	800	ААНБ-ын албан хаагчийн шилжилтийн тоо өмнөх жилүүдэд гарч байгаагүй.	Жилд	ЗДТГ ААНБ	Статис- тик	-
Шинээр бий болсон ажлын байр	Тоо	1026	1063	2500	5000	2021 онд 1026, 2022 онд 1063 ажлын байр бий болсон.	Жилд	ЗДТГ ААНБ	Статис- тик	37